

ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ҮНЭ

/2017 оны 1-р сарын 11-нээс 2-р сарын 8-ны байдлаар, төгрөгөөр/

№	Барааны нэр, төрөл	I/11	I/18	I/25	II/01	II/08
1	Гурил, I зэрэг, кг	1200	1200	1200	1200	1200
2	Хонины мах, кг/ ястай/	5000	5000	5000	5500	5500
3	Үхрийн мах, кг /ястай/	6000	6000	6000	6500	6500
4	Ямааны мах /ястай /	3500	3500	3500	4500	4500
5	Элсэн чихэр, кг	2250	2200	2200	2200	2200
6	Цагаан будаа, кг	2200	2200	2200	2200	2200
7	Шингэн сүү, л	1800	1800	1800	1800	1900
8	Ямааны ноолуурын үнэ 1 кг- цагаан	зарагдаагүй	зарагдаагүй	зарагдаагүй	зарагдаагүй	зарагдаагүй
9	- Бор ноолуур	зарагдаагүй	зарагдаагүй	зарагдаагүй	зарагдаагүй	зарагдаагүй
10	Бензин, АИ-80, 1 литр	1450	1450	1450	1450	1480
11	Бензин, АИ-92, 1 литр	1530	1530	1530	1530	1630
12	Дизелийн түлш, 1 литр	1620	1620	1620	1620	1720

Гол нэрийн барааны үнийн 7 хоногийн мэдээгээр аймгийн төвд 2017 оны 1-р сарын 11-нээс 2-р сарын 8-ны хооронд мах, элсэн чихэр, шингэн сүү, шатахууны үнэ өөрчлөгдөж гурил, цагаан будааны үнэ тогтвортой байв. Энэ хугацаанд ноолуурын арилжаа хийгээгүй.

Махны үнэ. 2-р сарын 1-ний мэдээгээр өмнөх долоо хоногийн мөн үеэс хонины мах 10 хувиар, үхрийн мах 8.33 хувиар, ямааны мах 28.6 хувиар тус тус өсч харгалзан 5500, 6500, 4500 төгрөгийн ханштай болов.

Гурил, элсэн чихэр, цагаан будаа. Гурил, цагаан будааны үнэ сүүлийн 5 долоо хоногийн турш тогтвортой байлаа. Элсэн чихрийн үнэ 1-р сарын 11-ий хүртэл 2250 төгрөгийн ханштай байсан бол 1-р сарын 18-ны мэдээгээр өмнөх 7 хоногоос 2.2 хувь буюу 50 төгрөгөөр буурч сүүлийн дөрвөн долоо хоног хэвээр байна.

Шингэн сүү. Шингэн сүүний үнэ 2-р сарын 8-нд өмнөх 7 хоногийн мөн үеэс 5.5 хувиар өсч 1900 төгрөгийн үнэтэй болов.

Шатахуун. 2-р сарын 8-нд АИ-80 1480 төгрөг, АИ-92 1630 төгрөг, дизелийн түлш 1720 төгрөгийн ханштай байгаа нь өмнөх долоо хоногийн мөн үеэс АИ-80 2.1 хувиар, АИ-92 6.5 хувиар, дизелийн түлш 6.2 хувиар тус тус өсчээ.

